



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн "Мэдээлэл технологийн алба" ОНӨААТҮГ-ын
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2026/05/НА-СТА-ОНА

Цахим хуудас:

www.audit.mn

Дархан-Уул аймаг

2026 он

Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр:

Утас: 70378845

Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Батцэцэг

Утас: 70373089

Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитор: Ч.Мөнхбаяр

Утас: 89275858

Цахим хаяг: tsesb.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
3.1 Компани, түүний үйл ажиллагаа	10
3.2 Компанийн гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	11
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	12
4.1 Ерөнхий зүйл	12
4.2 Материаллаг байдал	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	14
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	16

Товчилсон үгийн жагсаалт

ААН	Аж ахуйн нэгж
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани



“МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН АЛБА” ОНӨААТҮГ-ЫН
ДАРГА С.БАЯРАА ТАНАА

**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 92

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Мэдээлэл технологийн алба” ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар өөрчлөлтгүй санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв илэрхийлсэн байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд орон нутгийн төсвөөс 2,964,282.0 мянган төгрөг, өөрийн үйл ажиллагааны орлого 97,027.9 мянган төгрөг буюу нийт 3,061,309.9 мянган төгрөгийн орлого төлөвлөснөөс 3,061,309.9 мянган төгрөгийн орлого олж, 3,731,090.1 мянган төгрөгийг зарцуулж 669,780.2 мянган төгрөгийн алдагдалтай ажиллахад 747,816.8 мянган төгрөгийн элэгдлийн зардал шууд нөлөөлсөн байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд орон нутгийн төсвөөс 507,170.4 мянган төгрөг, өөрийн үйл ажиллагааны орлогоос 30,831.9 мянган төгрөг олж, 585,283.9 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж, 47,281.6 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан нь үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал нөлөөлсөн байна.

Аудитын гол асуудлууд

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

4526050272

Тус байгууллагын 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 35 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэл 98 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

A handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The stamp contains Mongolian text and a central emblem. The signature is stylized and extends across the stamp.


Ш.МӨНХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	11,631,933.46	2,981,968.82
1.1.2	Дансны авлага	2,630,100.01	1,041,145.70
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	41,129.70	
1.1.6	Бараа материал	7,447,436.37	9,428,254.55
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	3,680,000.00	-
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	25,430,599.54	13,451,369.07
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	101,332,367.08	70,178,557.26
1.2.2	Биет бус хөрөнгө	48,063,636.36	44,163,636.36
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	149,396,003.44	114,342,193.62
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	174,826,602.98	127,793,562.69
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	-	-
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	217,699.82	946,608.39
2.1.1.4	НДШ-ийн өглөг	480,336.72	
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	698,036.54	946,608.39
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	698,036.54	946,608.39
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	1,000,000.00	1,000,000.00
2.3.2	- хувийн	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	298,382,865.11	298,382,865.11
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(125,254,298.67)	(172,535,910.81)
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	174,128,566.44	126,846,954.30
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	174,826,602.98	127,793,562.69



2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/


Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	46,805,636.38	30,831,929.52
2	Борлуулалтын өртөг		
3	Нийт ашиг (алдагдал)	46,805,636.38	30,831,929.52
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого		
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	346,362,363.59	507,170,454.51
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	385,466,839.70	574,330,296.17
11	Санхүүгийн зардал	4,138,400.00	10,953,700.00
12	Бусад зардал		
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	3,562,760.27	(47,281,612.14)
19	Орлогын татварын зардал	356,276.03	
20	Татварын дараах ашиг (алдагдал)	3,206,484.24	(47,281,612.14)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	3,206,484.24	(47,281,612.14)
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
24	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		-
25	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		-
26	Бусад олз (гарз)		
27	Орлогын нийт дүн		-
28	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		



2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Лөгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл			298,382,865.11	(125,254,298.67)	174,128,566.44
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
3	Залруулсан үлдэгдэл			298,382,865.11	(125,254,298.67)	174,128,566.44
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					
5	Бусад дэлгэрэнгүй орлого					
6	Өмчид гарсан өөрчлөлт					
9	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл			298,382,865.11	(125,254,298.67)	174,128,566.44
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
11	Залруулсан үлдэгдэл					
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					
13	Бусад дэлгэрэнгүй орлого				(47,281,612.14)	(47,281,612.14)
14	Өмчид гарсан өөрчлөлт					
15	Зарласан ногдол ашиг					
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					
17	2025 оны 12-р сары 31-ний үлдэгдэл			298,382,865.11	(172,535,910.81)	126,846,954.30



2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	439,484,800.00	591,021,475.00
	Татаас, санхүүжилтийн орлого	46,805,636.38	538,002,384.03
	Бусад мөнгөн орлого	392,679,163.62	53,019,090.97
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	382,716,839.33	596,271,439.64
	Ажиллагчдад төлсөн	196,552,004.00	302,946,436.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	57,066,753.12	86,776,495.61
	Бараа материал худалдан авахад төлсөн	20,965,456.88	22,001,418.15
	Ашиглалтын зардалд төлсөн	43,257,720.75	637,272.72
	Татварын байгууллагад төлсөн	57,076,504.58	80,784,836.29
	Даатгалын төлбөрт төлсөн		70,000.00
	Бусад мөнгөн зарлага	7,798,400.00	103,054,980.87
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	56,767,960.67	(5,249,964.64)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	45,657,636.37	3,400,000.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	45,657,636.37	3,400,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	11,110,324.30	(8,649,964.64)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	521,609.16	11,631,933.46
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	11,631,933.46	2,981,968.82

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/Мян.төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 оны гүйцэтгэл	2025 оны		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт						
2	Нийт орлого	м/төг	393,168.00	549,823.30	538,002.30	(11,821.00)	98%
	Үүнээс: Татаас санхүүжилт орлого	м/төг	346,362.40	528,163.30	507,170.40	(20,992.90)	96%
	Өөрийн орлого		46,805.60	21,660.00	30,831.90	9,171.90	142%
3	Нийт зардал	м/төг	389,605.20	549,823.30	585,283.90	35,460.60	
	Үүнээс:						
	а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	м/төг	-	-	-	-	-
	б) Ерөнхий ба удирдлагын зардал	м/төг	389,605.20	549,823.30	585,283.90	35,460.60	71%
	в) Хөрөнгө оруулалт их засвар	м/төг	-	-	-	-	-
4	Цэвэр ашиг, алдагдал	м/төг	3,562.80	-	(47,281.60)	(47,281.60)	-

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,400.0 мянган төгрөгийн алдаа¹ Нягтлан бүртгэлийн тухай хуулийн 5.1.4, 18.1, НББОУС-1 “Санхүүгийн тайлангийн тодруулга”, НББОУС-7 “Мөнгөн гүйлгээний тайлан”, СТОУС 7 “Санхүүгийн хэрэглүүр, тодруулга”-т заасантай тус тус нийцээгүй тул аудитын явцад дараах байдлаар залруулав. Үүнд:

- Мөнгөн гүйлгээний тайланд өөрийн худалдан авахад төлсөн үндсэн хөрөнгийн төлсөн 3,400.0 мянган төгрөгийг дутуу тайлагнасныг мөнгөн гүйлгээний тайлангийн үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн Дүн хэсэгт нэмж залруулав

Мөн аудитаар нийт 2,875.0 мянган төгрөгийн алдаа зөрчил¹ илэрч 1 зөвлөмж хүргүүлэв.

5.1 Зөвлөмж²

5.1.1. Илрүүлэлт:

Тус байгууллагын Мэдээлэл техник хангамж, хэвлэл мэдээллийн чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар 2021 онд дүрмийг шинэчлэн баталсан бөгөөд 2025 онд и-спортын арга хэмжээг Санхүүжүүлж, байгууллагын чиг үүрэгт хамааралгүй и-спортын арга хэмжээнд 2,875.0 мянган төгрөг зарцуулж, үр ашиггүй зардал гаргасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “*Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ*”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль 15 дугаар зүйлийн 15.2-т “*Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ*” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15.2-т заасныг хэрэгжүүлэн ажиллах

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5³-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2026 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² 20.5. Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

³ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж			
	Дүн		Дүн		Дүн		Дүн		Залруулсан		Залруулаагүй		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөнгөн гүйлгээний тайланд өөрийн худалдан авахад төлсөн үндсэн хөрөнгийн төлсөн 3,400.0 мянган төгрөгийг дутуу тайлагнасныг мөнгөн гүйлгээний тайлангийн байна.	1	3,400.0	1	3,400.0	-	-	-	-	1	3,400.0	-	-	-	-
Дүн	1	3,400.0	1	3,400.0	-	-	-	-	1	3,400.0	-	-	-	-

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Дүн		Дүн		Дүн		Дүн		Тоо		Тоо	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус байгууллагын Мэдээлэл техник хангамж, хэвлэл мэдээллийн чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар 2021 онд дүрмийг шинэчлэн баталсан бөгөөд 2025 онд и-спортын арга хэмжээг 2,875.0 мянган төгрөгөөр санхүүжүүлсэн байна.	1	2,875.0	-	-	-	-	1	2,875.0	-	-	-	-
Дүн	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-

/мянган төгрөгөөр/